

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-5

1. Байнгын хорооны тогтоолын төсөл /“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/ 3-5

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
10 дугаар сарын 14-ний өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 38 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Ш.Бямбасүрэн, М.Мандхай, А.Ундраа;
Эмнэлгийн чөлөөтэй: П.Батчимэг, С.Цэнгүүн;
Тасалсан: Ж.Алдаржавхлан, Н.Алтанишагай, Н.Батсүмбэрэл, Х.Баттулга,
Ж.Ганбаатар, Б.Найдалаа.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж ““Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, М.Энхцэцэг, Ч.Лодойсамбуу, Д.Батбаяр нар үг хэлэв.

Р.Сэддорж: ““Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 10 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
14 цаг 38 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Бадамсүрэн гишүүн орон нутагт томилолттой, Батчимэг гишүүн эмнэлгийн чөлөөтэй, Бямбасүрэн гишүүн орон нутагт томилолттой, Мандухай гишүүн гадаадад томилолттой, Ундраа гишүүн гадаадад томилолттой, Цэнгүүн гишүүн эмнэлгийн чөлөөтэй. Ирсэн гишүүд Батболд, Батнайрамдал, Батишугар, Ганхуяг, Жаргалан, Лодойсамбуу, Лувсанжамц, Мөнхсоёл, Соронзонболд, Цогтгэрэл, Энхтүвшин, Энхцэцэг гишүүд хүрэлцэн ирсэн байна. Хуралд ирсэн гишүүддээ баярлалаа. Ирц 52 хувьтай байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

2025 оны хөгжлийн төлөвлөгөөний ажлын хэсгийн бүрэлдэхүүний нэрсийг дараах байдлаар нэр дэвшүүлээ. Өнгөрсөн хаврын чуулганаар 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг хуулийн хүрээнд, хуулийн хугацаанд амжуулахаар Улсын Их Хурлаар хэлэлцэх үед ажиллаж байсан ажлын хэсгийн гишүүдээс одоо Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг байгаа учраас Ганхуяг гишүүнийг үргэлжлүүлэн ажиллуулж, ажлын хэсгийн ахлагчаар, ажлын хэсгийн гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал, Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл, Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу, Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл, Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн, Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин, Улсын Их Хурлын гишүүн Батболд, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан, Улсын Их Хурлын гишүүн Энхтуяа гэсэн 11 хүн, 10 хүнтэй, ажлын хэсгийн даргатайгаа 11 хүн.

Ингээд орж ажиллахаар саналаа ирүүлсэн гишүүдийг оруулаад Байнгын хорооны тогтоолыг уншиж танилцуулъя. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоол. 2024 оны 10 сарын 14-ний өдөр, Улаанбаатар хот. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай гээд саяын саяын 11 гишүүн байна.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсэгт

зөвшөөрсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна. Бусад Улсын Их Хурлын ямар ч гишүүн таслах эрхгүйгээр ажлын хэсгийн хуралдаанд орж болно. Саналаа хэлж болно, санал хураалтад оролцохгүйгээр.

Ингээд ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу? Саналаа юугаа дараад өгчхөөрэй. 3 гишүүн байна, болох уу? Энхцэцэг гишүүнээр саналыг тасаллаа. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг гишүүний микрофоныг өгье.

Х.Ганхуяг: Энэ өдрийн мэндийг хүргэе. Ажлын хэсэгт орж ажиллах гишүүдэд анхааруулахад болж өгвөл ажлын хэсгийн хурлыг таслахгүйгээр цөмөөрөө 2 дахь, 3 дахь өдрүүдэд багтаагаад санал хураалтуудаа бүгдийг нь дуусгаад, цэгцлээд, дуусгах шаардлагатай.

Тэгээд Байнгын хорооны даргаас хүсэхэд бол цөмөөрөө 4 дэх өдрийн өглөө Байнгын хороогоо хуралдуулаад, 4 дэхийн чуулганаар оруулахгүй бол хугацааны хувьд ерөөсөө амжихааргүй маш давчуу хугацаатай байгаа. Энэ нь батлагдаж дараагийн төсөв батлагдах, хэлэлцэж эхлэх ийм хуультай юм. Тэгэхээр болж өгвөл 1 дүгээрт ажлын хэсгийн гишүүд маань яг цагаа гаргаад яг 2 дахь, 3 дахь өдөр бүтэн суугаад, 4 дэхэд Байнгын хороогоор ороод, 4 дэхдээ багтаагаад чуулган руу орох л ийм л цаглавартай байхгүй бол энэ цаг хугацааны хувьд ерөөсөө амжихааргүй байгаа шүү гэдгийг л хэлэх гэсэн юм.

Р.Сэддорж: Байнгын хороо бол 3 дахид Даргын дэргэдэх зөвлөлийн шийдвэрээр Байнгын хороо 3 дахид 14 цагаас, 4 дэхэд чуулганаар хэлэлцүүлэхээр ингээд орчихсон юм байна. Тийм учраас шахуухан ажиллах хэрэгтэй юм байна. Энхцэцэг гишүүний микрофоныг өгье.

М.Энхцэцэг: Сэддорж даргаа би нөгөө Байнгын хороонд орох хүсэлтээ тан руу илгээсэн санагдаад, тэгээд Байнгын хороонд, Байнгын хороо гэнэ ээ ажлын хэсэгт орох хүсэлтээ илгээсэн. Тэгээд ажлын хэсэгт орох хүсэлтэй байна л даа гишүүнээр.

Р.Сэддорж: Энхцэцэг гишүүн өөрийн саналаар ажлын хэсэгт орохоор санал хэллээ. Лодойсамбуу гишүүний микрофон өгье.

Ч.Лодойсамбуу: Өдрийн мэнд хүргэе. Ажлын хэсгээс гарах саналтай байна даргаа. Нөгөө хариуцсан ажлын хэсэг, тэгээд өөрийн багтсан ажлын хэсгүүдийн тоо бас хэтэрхий ихдээд байна. Тэгээд ажлынхаа бүтээмжийг бодоод гаръя гэсэн саналтай байна, дэмжиж өгөөрэй.

Р.Сэддорж: Ингээд нэг гишүүн нэмэгдээд, нэг гишүүн өөрийн хүсэлтээр гараад ингээд 11 болж байна уу. Өөр саналтай гишүүд байхгүй байна. Асуулт, юутай асуулт яах вэ? Үгүй ээ үгүй ажлын хэсэгтэй холбоотой. Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Санал хураалтыг явуулъя. Саналын томъёолол, Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтыг алх тогшисоноос хойш цаг явж эхэлнэ. Санал хураалт. Олонхын саналаар дэмжигдлээ. Миний энэ юу ажиллахгүй байгаа учраас дэмжсэнд санал өгөхийг хүсэж байна. Ингээд хэдэн хувийн саналаар байна вэ? 76,9 хувь, дээр нь нэг хүн, нэг гишүүний санал нэмээд санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа. Лхагва гарагт Байнгын хороогоор 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн хэлэлцүүлгийг явуулах тул

Ажлын хэсэг маргааш идэвхтэй хуралдаж, төслийг хэлэлцүүлэгт бэлтгэхийг хүсье. Эдийн засгийн, байж байгаарай манайхан бүгд байж байгаарай. Микрофон нээе Далайн Батбаяр гишүүний.

Д.Батбаяр: Гишүүддээ баярлалаа. Энд байж байгаа. Би нөгөө дэгтэй тэр болгон танилцаж чадахгүй байгаад байгаа учраас нэг тодруулах зүйл байгаад байна л даа. Би Улсын Их Хурлын чуулган дээр нэг тодорхой санал гаргаад, зарчмын зөрүүтэй санал гаргаад, танай Байнгын хорооны хамгийн эхний хуралдаанаар уг нь оруулахаар ярьж тохироод өөрийнхөө хүсэлтийг саналаа бичгээр өгсөн. Тэгээд одоо ингээд тараад явчих гэж байгаа учраас яг ямархуу байдлаар явж байгаа юм бол хэлэлцэх асуудалд орж чадсан юм болов уу, үгүй юм болов уу? Эдийн засгийн хөгжлийн хөтөлбөртэй холбоотой л юм яваад байгаа юм л даа. Эсвэл би Ажлын хэсэгт нь хандах ёстой юм болов уу? Тийм, ажлын хэсэгтээ өгөөд явчих юм уу?

Р.Сэддорж: Зарчмын зөрүүтэй Далайн Батбаяр гишүүний саналыг авчихсан байгаа юм байна. Тэгээд өнөөдөр багтаагаад та Ажлын хэсэгт өгчих. Авчихсан байгаа юм байна, угаасаа шилжүүлчих юм байна. Манайх өгчих юм байна, өгчих юм байна, ажлын алба өгчих юм байна. Баярлалаа. Маргааш 10-аас хуралтай.

14.48 цаг

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хуралдааны хэлэлцэх асуудал үүгээр дуусаж байна. Хуралдаан өндөрлөж байгааг мэдэгдэж байна. Идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

